

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:	2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр
Зээлийн дугаар ба нэр:	Зээл № 3129-МОН: Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Төсөл 2
Тендер шалгаруулалтын дугаар:	ЗТХЯ/202011095
Гэрээний дугаар ба нэр:	Багц No.1: Ховд аймгийн Манхан сумын төлбөр авах цэгийн барилга Багц No.2: Баян-Өлгий аймгийн Сагсай сумын төлбөр авах цэгийн барилга
Тендер хүлээн авах огноо ба цаг:	2021 оны 01 дугаар сарын 04-ны өдрийн 15:30 цаг (Улаанбаатарын цагаар)

1. Монгол Улс Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх)-наас Зээл №3129-МОН: Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Төсөл 2-ыг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан.
2. Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам (цаашид “Захиалагч” гэх) эрх бүхий тендерт оролцогчдоос доор дурдсан ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Гэрээний дугаар	Гэрээний нэр	Барилгын ажлын бүрэлдэхүүн	Хугацаа
Багц No.1	Ховд аймгийн Манхан сумын төлбөр хураах цэгийн барилга	1.Авто замын өргөтгөл 2.Төлбөр хураах байр, цахимжуулах систем, амрах байр 3.Цахилгаан, гэрэлтүүлэгийн угсралт	6 сар
Багц No.2	Баян-Өлгий аймгийн Сагсай сумын төлбөр хураах цэгийн барилга	1.Авто замын өргөтгөл 2.Төлбөр хураах байр, цахимжуулах систем, амрах байр 3.Цахилгаан, гэрэлтүүлэгийн угсралт	6 сар

3. Энэхүү дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалт нь АХБ-ны Нэг үе шаттай: нэг дугуйт аргаар явуулах ба АХБ-ны харьяа эрх бүхий орны оролцогчдод нээлттэй байна. Зөвхөн доор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендерт оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно. Үүнд:

Шалгуур үзүүлэлт	Багц 1
Барилгын ажлын жилийн дундаж борлуулалт (сүүлийн 3 жилд, 2017, 2018, 2019)	> 500,000,000 төгрөг (таван зуун сая төгрөг)
Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлага	> 300,000,000₮ (гурван зуун сая төгрөг)
Барилга угсралтын хоёроос доошгүй гэрээт ажилд оролцсон сүүлийн 3 жилийн туршлага (2017, 2018, 2019)	500,000,000 төгрөгөөс доошгүй байх. Хоёр багцад (Багц-1 болон Багц-2 оролцвол 1 тэрбум төгрөгөөс доошгүй байна)
Үндсэн үйл ажиллагааны авто замын барилгын ажлын туршлага	140м3 асфальт бетон хучилттай зам барьсан. Хоёр багцад 280м3 барьсан байх.

Үндсэн үйл ажиллагааны оффис эсхүл орон сууцны барилгын ажлын туршлага

200м2 талбай бүхий 2 давхар оффисийн эсхүл орон сууцны барилга барьсан байх. Хоёр багцад 400м2 байх.

- Ажил гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл:
 1. 2.8.2.6. Зам, талбайн тохижилтын ажил хийх, засварлах (багц тус бүрт)
 2. Б.А-2.1 Цутгамал болон угсармал төмөрбетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийх (багц тус бүрт)
- 4. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Тендер хүлээн авах этгээд:	Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Одбаяр;
Байгууллагын нэр:	Зам, тээврийн хөгжлийн яам
Хаяг:	Чингисийн өргөн чөлөө -11, Засгийн газрын 13 дугаар байр
Давхар ба өрөөний дугаар:	4 давхар, 401 тоот
Хот/дүүрэг:	Улаанбаатар хот
Шуудангийн дугаар:	14251
Имэйл хаяг:	odbayar.b@mrttd.gov.mn
Улс:	Монгол Улс

- 5. Эрх бүхий тендерт оролцогч тендерийн баримт бичгийг худалдан авахыг хүсвэл:
 - Багц-1: Ховд аймгийн Манхан сумын төлбөр хураах цэгийн барилга болон Багц-2: Баян-Өлгий аймгийн Сагсай сумын төлбөр хураах цэгийн барилгын ажлын тендерийн баримт бичиг авах хүсэлтийг дээрх хаягийн дагуу бичгээр ирүүлнэ.
 - Нийт 200,000 /Хоёр зуун мянган /төгрөгтэй тэнцэх буцаан үл олгогдох хураамжийг бэлнээр төлнө.
- 6. Тендерийг дээр дурдсан хаягаар, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас (2021 оны 01 дугаар сарын 04-ны өдөр 15 цаг 30 мин) өмнө тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх эцсийн хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссан даруйд тендерт оролцогчдын төлөөллийг (хэрэв тэд оролцохыг хүсвэл) байлцуулан Зам, тээврийн хөгжлийн яамны 301 тоот хурлын танхимд 2021 оны 01 дугаар сарын 04-ны өдөр 16:00 цагт нээнэ.